

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Будын Лувсанцэрэн	Дугаар	L047
Оршин суугаа аймаг	Дорнод аймгийн	Оршин суугаа сум	Дашбалбар сум
Төрсөн газар	Дорнод аймгийн Дашбалбар сум	Төрсөн он	Хулгана жилтэй
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Угтамтэгчилэн хийд	Сүм хийдийн дугаар	ДОБД 029
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 6	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Дорнод аймгийн Баяндун сумын Угтамтэгчинлэн хийд

-Угтамын хийдийг гар бие оролцон сэргээсэн юм байна. Энэ тухайгаа ярихгүй юу?

Шашин ном сэргээд Угтамын хийдийг сэргээх ажлыг санаачлалцан гар бие оролцож явсан. Манай энэ хойд сумдынхан, дээр үед хийдэд шавилан сууж байсан настайчууд энэ Угтамын хийдийн сэргээх ажилд их санаачлагатай оролцсон. Тэнд хийдийн туурин дээр бид нэлээн удаан хугацаагаар байсан. Тэгээд байж байхад энд тэндгүй үхсэн нүх байсан. Энэ ямар учиртай нүх вэ гэтэл Оросууд тэр хавьд чинь хайгуул хийж нэг өвөлжсөн юм. 24 цагийн гэрэлтэй. Зүүн хажууд нь том бензиний ёскост зоочихсон. Тэгж тэнд байрлаж байхдаа нөгөө багажаараа янз бүрийн алт эрдэнэс хайж ухаж төнхөж байдгийг нь ухаад авчихсан байгаа юм. Угтамын хийдийн суурь муурийг ухаж төнхөж явсан хүмүүс юм билээ л дээ. Тэгээд тэр өвгөн ламыг танай гэр хаана байсан юм гэсэн. Булгийн эхэнд зааж байгаа юм. Тэгээд нэг шаахайтай мотацикльтой хүн өвгөнийг суулгаад гэрийнх нь буурийг нь очиж үзэхгүй юу. Танайх алт мөнгөө булсан уу? гэсэн. Байшингийнхаа баруун хойд буланд нэг

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

жигжигхэн ваартай цагаан мөнгө булсан юм гэсэн. Тэрийг чинь үздэг хэрэг ээ гэсэн.Тэгсэн яг тэр байшингийн суурийн баруун хойно нь нүх байгаа юм шүү дээ. Оросууд аль хэдийн ухаад авчихсан байсан. Тэгж жил гаран болоход тэр мэтийн юмыг ухаж авсан байгаа юм. Том том байшингийн сууринд тэгж ухсан нүх олон байсан. Тэгээд тэр Оросууд чинь явахдаа халдвартай гэж хэлээд байшингийн хаалган дээр бичиг наагаад явчихсан. Мардайн л Оросууд шүү дээ.